

**НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ**

# 2022 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2022.12.05

АГУУЛГА


НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ........ 3

1.1.”АЛСЫН ХАРАА 2050” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ........ 3

1.2. “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД ........ 3

1.3. “НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД ........ 6

ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ........ 10

2.1. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ........ 10

2.2. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ ........ 14

ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ........ 26

**НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ**
**2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2022 оны12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2021 он/ | Зорилтот түвшин /2022 он/ | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **1.1.”АЛСЫН ХАРАА 2050” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 2.2.16.Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна. | | | | | | | |
| 1.1.1 | Эх, хүүхдийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэж, эмч, ажилчдын чадварыг тогтмол сайжруулна. | ЭМДС | Тусламж, үйлчилгээний үзүүлэлт, Эх, хүүхдийн эндэгдлийн тоо | Эхийн эндэгдэл-0<br>0-16 хүүхдийн эндэгдэл-68 | Дуудлагын эмчийн тоог нэмэгдүүлэх, осол гэмтэл, хүүхдийн эндэгдлээс сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг 3 удаа зохион байгуулсан байна. | Эхийн эндэгдэл-0<br>0-16 хүүхдийн эндэгдэл-74<br>Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын хүрээнд нийт 6 аян зохион байгуулсан.<br>Өдөрт гардаг 40 түргэн тусламжийн багийн тоог 41-48 болгон нэмэгдүүлсэн. | 100% |
| **1.2. “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 2.1.2. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна. | | | | | | | |
| 1.2.1 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | ЭМДС | Сургалт зохион байгуулсан тоо | Сургалт-3 | Халдварт өвчнөөс | Халдвараас сэргийлэх зааврын дагуу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | талаар эмч, ажилчид, иргэдэд тогтмол мэдээлэл, сургалт зохион байгуулах | | Мэдээлэл хүргэсэн тоо | Хамрагдсан ажилчид-300 | урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалтыг тогтмолжуулж цахим хуудас, мэдээллийн самбараар тогтмол мэдээлэл хүргэх. | ажиллахаар 3 чиглэлээр 16 ажил төлөвлөн ажиллаж байна. Байгууллагын цахим хуудаст Тууралтад халдварт өвчнөөс сэргийлэх, менингококкт халдвар, шүд эрүүл бол бие эрүүл, гар угаахын ач холбогдол, ТТТӨ-өөс сэргийлэх, Ковидын үеийн мэдээ, зөвлөмж зэрэг 67 зурагт хуудас байршуулсан байна. ЭХЭМҮТ-өөс Томуу , томуу төст өвчний тархалтыг үед баримтлах оношилгоо, эмчилгээний долоодугаар удирдамжийн дагуу салбарууд сургалт зохион байгуулж, нийт 77 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. “Менингококкт халдвар” сэдвээр хүүхдийн эмч нар сургалт орж 75 эмч хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Коронавируст халдвар (covid-19)-ын дараах хүндрэл" сэдвээр АУ-ны доктор Ц.Намхайдорж эмч сургалт орж нийт эмч нар хамрагдсан. | |
| 2.1.4.Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ: | | | | | | | |
| 1.2.2 | Түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгах, алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй нутагт оршин сууж байгаа иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил зохион байгуулна. | ЭМДС | Түргэн тусламжийн статистик үзүүлэлт | 2021 он<br>нийт дуудлага-264,254<br>Яаралтай дуудлага-217,143<br>20 минутын очилт-195,800 | Түргэн тусламжийн дуудлагын хугацааг багасгах, газар зүйн алслагдсан саад бэрхшээлтэй нутагт оршин суух иргэдэд түргэний тусламж үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх талаар холбогдох байгууллагуудтай төлөвлөгөө гарган хамтарч ажиллан 100% үр дүнтэй ажиллан 20 минутын очилтын хувийг 0.1%-р | 2022.11.30 нийт дуудлага- 3438817 /+17,8%/<br>Яаралтай дуудлага-299,888 /38,1%/<br>20 минутын очилт-270,199 /+0,2%/<br><br>20 минутын очилтын хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,2%-р өссөн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэгдүүлсэн байна. | | |
| **1.3. “НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1.1.1.5. Нөхцөл байдлын мэдээллийг олон нийтэд үнэн зөв хүргэх, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэнэ. | | | | | | | |
| 1.3.1 | Коронавируст /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлт бүлгийн сурталчилгааны материалыг түгээх, танилцуулах | - | Мэдээлэл нийтэлсэн тоо | Цахим хуудсаар дамжуулан 25 мэдээлэл хүргэсэн. | Байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хуудаст 10 удаагийн коронавируст халдвараас сэргийлэх талаар мэдээлэл хүргэнэ. | Маскаа зөв хэрэглэе видео зөвлөмж бэлтгэн сошиалаар дамжуулан иргэдэд хүргэсэн. Хөхүүл эхчүүд Ковид-19 эсрэг вакцинд хамрагдаж болох уу зөвлөмж бусад ЭМЯ, НЭМГ, ЭМХТ, НЭМҮТ-ээс гаргасан зурган зөвлөмжүүдийг 96 удаа байршуулсан байна. | 100% |
| ЗДҮАХ 1.1.2.1 Нийслэлийн гамшгаас хамгаалах албадад “Шуурхай штаб” байгуулж, тохиолдлын голомтод үүрэг гүйцэтгэх шуурхай арга хэмжээний багийн бэлэн байдлыг ханган ажиллана. | | | | | | | |
| 1.3.2 | Төвийн шуурхай удирдлагын нэгжийн журмыг батлуулах | - | Батлагдсан журам | - | Төвийн шуурхай удирдлагын нэгжийн бүтэц, журмыг баталсан байна. | Хан-Уул салбарт шуурхан нэгжиийн ажиллах өрөөг бэлтгэсэн. | 100% |
| ЗДҮАХ 2.1.1.1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг оношилгоо, эмчилгээг сайжруулна. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.3 | Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн талаар иргэдэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах | ЭМДС | Халдварт бус өвчлөлийн талаар иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгааны тоо, хувь | Сургалт-4 Хамрагдсан хүний тоо-425 | Сургалт сурталчилгаа 6 удаа хийгдэж, 840 хүн хамрагдсан байна. | 3-4-р саруудад НЭМГ-ын онлайн сургалтад хамрагдаж НЭМГ болон ӨЭМТ-тэй хамтарсан хэлэлцүүлэг хийсэн. 2022.03.20-нд ЭМЯ-тай хамтран Архины хэрэглээний хор уршиг сэдвээр зөвлөмж бичлэг бэлдэн МҮОНТ-ээр явуулсан. Архи тамхины хэрэглээний хор уршиг сэдэвт сургалтыг ДЦС-ийн нийт 150 ажилтныг хамруулан зохион байгуулсан. “Жирэмслэх насны эмэгтэйн тамхины хор хөнөөл” сэдэвт зөвлөмжийг FM 88.3-т шууд эфирээр дамжуулсан. Чихрийн шижин өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар нийт эмч нарт сургалт хийсэн. | 100% |
| 1.3.4 | Эмч, эмнэлгийн ажилчдад эмийн зохистой | ЭМДС | Сургалтын тоо | Сургалт-3 Хамрагдсан хүний тоо-265 | 4 удаагийн сургалт /аян/-д 230 эмч, | 2022.04.01-ний өдөр “Эмийн жор бичилт, эмийн гаж нөлөөг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэглээний талаар сургалт зохион байгуулах | | Хамрагдах эмч, эмнэлгийн ажилчдын тоо | | эмнэлгийн мэргэжилтэн хамрагдана. | бүртгэх" сэдэвт сургалтад 7 их эмч, 2 сувилагч хамрагдсан. "Антибиотикийн зохистой хэрэглээ" сэдэвт өдөрлөгийг 2022.04.01-ны өдөр зохион байгуулан нийт 402 ажилчдад мэдээлэл хүргэсэн. Мөн 3 төрлийн сэдвээр нийт 60ш зөвлөмж гарган тараасан. 2022.09.14-ний өдөр эмч нартаа "Жор хэрхэн бичих талаар", "Хүүхдэд хэрэглэх зарим эмийн эмчилгээ""Өвдөлтийн менежмент болон хавсарсан найрлагатай эмийн мэдээлэл", сэдэвт сургалтыг орж нийт 140 эмч 33 эмийн санч, сувилагч нар хамрагдсан. Дуудлагын цүнх дэх эм тарианы хэрэглэх заалт, хэмжээ, эсрэг заалтаар мэдээлэл бэлдэж эмч нарт гарын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авлага бэлдэн тараасан. | |
| 1.3.5 | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах | - | Мэдээлэл зөвлөмжийн тоо, цахим мэдээллийн тоо | 10 чиглэл, 30 удаа, 350 хүнд мэдээлэл, цахим зөвлөгөө | Мэдээлэл цахим зөвлөгөө, сургалт, 550 хүнд хүргэсэн байна. | Эмнэлгийн цахим хуудас болон фейсбүүк хуудсанд эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл 43-г байрлуулж Цахим хуудаст 212,7 мянган зочин хандсан байна. Мөн FM 88.3 шууд эфирт ЭМ-ийн 37 чиглэлээр 26 удаа мэдээ, мэдээлэл. зөвлөмж, сэрэмжлүүлэг, зөвлөгөө анхааруулгыг дамжуулсан. | 100% |
| ЗДҮАХ 2.1.3.2 Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна. | | | | | | | |
| 1.3.6 | Эмнэлгийн ажилтнуудыг дархлаажуулалтад хамрагдахын ач холбогдлыг сурталчлах, урвал хүндрэлээс сэргийлэх талаар сургалт зохион байгуулах. | ЭМДС | Хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хувь | - | 1 удаагийн сургалтад ажилчдыг 100 хувь хамруулна | СБЭМТ-ийн дархлаажуулалт хариуцсан эмчтэй хамтран 2022.03.22-ны өдөр НТТТ-ийн даргаар удирдамж батлуулан нийт ажилчдад В гепатитын дархлаажуулалтын ач холбогдлын талаар танилцуулах сургалт хийсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022.10.19-20-ны өдрүүдэд нийт ажилчдад цахимаар томуугийн вакцины танилцуулга, аяа холбогдол, хариу урвалын талаар халдвар судлаач Д.Нямсүрэн сургалт хийж нийт ажилчид хамрагдсан. | |
| 1.3.7 | Ажилтан ажиллагсдыг дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулах | ЭМДС | Дархлаажуулалтад хамрагдсан хүний тоо, хувь | Ковидын вакцинжуулалт 383 хүнд хийгдсэн байна. | Томуугийн вакцин 380 хүн/тун гепатит-В 130 хүн/тун, тарваган тахал 120 хүн/тун, Ковидын вакцинжуулалт 380 хийгдсэн байна. | В гепатитын эсрэг дархлаажуулалтад 1-р тунд 85, 2-р тунд 40 ажилчид хамрагдсан. Томуугийн вакцинд нийт 324 ажилчид хамрагдсан. Бусад ажилчид жирэмсэн болон эрүүл мэндийн шалтгааны улмаас хамрагдаагүй. | 100% |
| **ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 2.1. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 2.1.1 | НЭМГ-ын даргын А/71 тоот тушаалын дагуу байгууллагын тайланг цаг хугацаанд нь хүргэж дүгнүүлэх. | - | НЭМГ-т хүргүүлсэн тайлангийн тоо, үнэлгээний дүн | НЭМГ-т цаг тухай бүрд нь тайлан мэдээг хүргүүлсэн. | Заасан хугацаанд биелэлтийг тайлагнаж ажиллана. | Хагас жилийн байдлаар 13 төрлийн тайланг 2022.06.10-ны өдрийн дотор НЭМГ-т хүргүүлсэн. Жилийн эцсийн тайланг цаг тухай бүрд нь явуулж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2 | Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн 2022-2026 оны стратеги, төлөвлөгөө боловсруулан батлуулах. | ЭМДС | Батлагдсан стратеги, төлөвлөгөө | 2017-2021 оны стратеги, төлөвлөгөө | 2022-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө батлагдана. | НТТТ-ийн 2022-2024 оны стратеги төлөвлөгөөг 2022.10.12-ны өдөр НЭМГ-ын даргаар батлуулсан. | 100% |
| Түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр | | | | | | | |
| 2.1.3 | Яаралтай дуудлагын 20 минутын очилтыг нэмэгдүүлэх. | ЭМДС | Минут, хувь | 2021 он яаралтай дуудлагын 20 минутын очилт 89,9% | Жилийн эцэст яаралтай дуудлагын 20 минутын очилт 90,1% | Яаралтай дуудлагын 20 минутын очилт 90,1% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,2%-р өссөн байна. | 100% |
| 2.1.4 | Нийт дуудлагын 20 минутаас дээших хүлээгдлийг бууруулах | - | 20 минутаас дээших хүлээгдлийн хувь | 2021 он нийт дуудлагын 20 минутаас дээших хүлээгдэл 50,2% | Жилийн эцэст нийт дуудлагын 20 минутаас дээших хүлээгдэл 41,5% | Дуудлагын 20 минутаас дээших хүлээгдэл 41.5% болж 8.7%-р нэмэгдсэн байна. | 100% |
| 2.1.5 | Автомашины парк ашиглалт болон техникийн бэлэн байдлын хувийг нэмэгдүүлэх | ЭМДС | Өдөрт үйлчлэх автомашины тоо, техникийн бэлэн байдал | ПАК 44%, ТББК 95% | Парк ашиглалтын хувь 54%-тай болж ТББК 98% | 2022 оны байдлаар ПАК 54%, ТББК 98% болж өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн байна.ПАК нэмэгдсэн актлах машины тоог нийт машинд оруулж тооцоогүй мөн өдөрт гарах автомашины тоог нэмэгдүүлсэнтэй холбоотой. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.6 | Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч ажиллах, яаралтай тусламжийн чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах. | ЭМДС | Төлөвлөгөөний тоо, хэрэгжилтийн хувь. Сургалтад хамрагдсан ажилчдын тоо | 2021 онд дүүрэг, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нийт 910 эмч мэргэжилтнүүд эд сургалт танхим, цахимаар зохион байгууллаа. | Нийслэлийн харьяа эмнэлэг болон холбогдох яаралтай тусламжийн эмнэлэг, нийгэмлэгтэй хамтран ажил зохион байгуулна. | НЭМГ-ийн харьяа 38 өрхийн эмнэлэг, 4 тосгоны эмнэлэг, 6 дүүргийн 344 эмч болон сувилагч нарт дээрх сэдвийн хүрээнд давхардсан тоогоор 59 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Тусламжийн Амилуулах нийгэмлэг хамтран яаралтай тусламжийн сургагч багш бэлдэх 32 цагийн сургалтын амжилттай зохион байгуулсан. Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооноос Глобаль сангийн дэмжлэгтэй Өрхийн эмч, мэргэжилтнүүдэд Коронавируст (Ковид-19)-ын халдварын хүндэрсэн тохиолдолд яаралтай, амь тэнссэн үеийн тусламж үзүүлэх дадлага сургалтыг Нийслэлийн түргэн тусламжийн төвтэй хамтран нийслэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 155 /салбар эмнэлэг орсон/ өрхийн эрүүл мэндийн төвийн 310 эмч мэргэжилтнүүдэд танхимаар, орон нутгийн 89/салбар эмнэлэг орсон/ өрхийн эрүүл мэндийн төвийн 356 эмч мэргэжилтнүүдэд цахимаар зохион байгуулсан.<br>Нийслэлийн түргэн тусламжийн төв болон АМДА олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтыг гамшиг, яаралтай тусламжийн олон улсын сургагч багш Сато Такуши болон тус төвийн Сургалт, гадаад харилцааны алба хамтран дараах сэдвийн хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 26,27-ны өдөр зохион байгуулсан.<br>AMDA олон улсын яаралтай тусламжийн сургагч багш Такуши | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сато багш болон Түргэн Тусламжийн Амилуулах нийгэмлэг хамтран яаралтай тусламжийн сургагч багш бэлдэх 32 цагийн сургалтын амжилттай зохион байгуулсан. Олон улсын сурагч багш Стефан Дэ Кренасэр Гэмтэл болон Амилуулах лавшруулсан тусламжийн 22 сургагч багш бэлдсэн ба AHA /american heart association/- удирдамжаар бэлдсэн | |
| 2.2. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ | | | | | | | |
| 2.2.1.Байгууллагын хөгжил, удирдлагын манлайлал, захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр | | | | | | | |
| 2.2.1.1 | Төвийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, үйл ажиллагааны дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулна. | - | Шинэчилсэн болон шинээр боловсруулсан баримт бичгүүдийн тоо | Үйл ажиллагаанд дүрэм, журам баримтлан ажилласан. | Нийт 113 баримт бичгийг /шинэчилсэн болон шинээр боловсруулсан, хэрэгжүүлж буй/ хэрэгжүүлж ажиллана. | НЭМГ-н даргын 2022.02.18-ны өдрийн А/17 тоот тушаалаар “Нийслэлийн түргэн тусламжийн төвийн дүрэм, бүтэц”-ийг шинэчлэн боловсруулж баталсан. | 100% |
| 2.2.1.2 | Байгууллагын онцлогийг харгалзан | - | Ажил дүгнэх шалгуур | Ажлын тайлан | Ажил дүгнэх үзүүлэлтийг | Ажилчдын ажлын үзүүлэлтийг журмын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжил тус бүрээр ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн батлуулах | | үзүүлэлтүүдийг баталсан баримт бичиг | | батлан ажил дүгнэх ажлын хэсэг гаргасан. 400 ажилтны ажлын үзүүлэлтийг дүгнэсэн байна. | дагуу үзүүлэлт тус бүрээр ажил дүгнэх ажлын хэсэг дүгнэн 1-р улиралд 252 ажилтанд, 2-р улиралд 296 ажилтанд, 3-р улиралд 157 ажилтанд, 4-р улиралд 289 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон. | |
| 2.2.1.3 | Ажилчдын цалин, урамшууллыг гүйцэтгэлд тулгуурлан нэмэгдүүлэх | 142.9 сая | Ажилчдад олгосон нэмэгдэл цалин, урамшууллын дүн | 396 ажилтанд 598,381.4 төгрөгийн урамшуулал олгосон. | Төвийн үйл ажиллагааг сайжруулж нийт ажилчдын цалинг 20%-р нэмэгдүүлнэ. | 2021 оны 1-р улиралд байгууллагын гүйцэтгэлийг харгалзан сар бүр 389 ажилчдад нийт 142,9 сая төгрөгийн цалингийн урамшуулал олгосон. 2022.09.05-ны өдрөөс нийт ажилчдын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн. | 100% |
| 2.2.1.4 | Ажилчдын идэвхтэй хөдөлгөөнд суурилсан урлаг, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх | 12.6 сая | Урлаг, спортын төрөл, хамрагдсан ажилчдын тоо | 2 удаагийн тэмцээнд 400 гаруй ажилтан хамрагдсан. | 6 төрөлтөд давхардсан тоогоор 850 ажилтан хамрагдана. Фитнес, усан спортоор ажилчдыг хөнгөлөлттэй | 2022.04.01-03-ны өдрүүдэд байгууллагын хэмжээнд 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулж нийт 380 ажилчид, байгууллагын биллиардын тэмцээн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хичээллүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | зохион байгуулж, 24 эмч, ажилчид хамрагдсан. 2022.10.20-11.13-ны өдрүүд НЭМГ-ын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнд оролцон 7 төрөлд 1-3-р байр эзлэн шилжин явах цомыг авсан | |
| 2.2.1.5 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ажлын байр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллана. | ЭМДС | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | - | Төлөвлөгөөний биелэлт 95%-с дээш байна. | СХС, БЗС, ТС, ХУС-ын урсгал, дулааны шугамын засварын ажлууд хийгдэж дууссан. Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар нийт эмч, инженер техникийн ажилчид, жолооч нарт сургалтыг үе шаттай зохион байгуулж байна. | 100% |
| 2.2.1.6 | Ажилчдын тав тухтай орчин бүрдүүлэх. | ЭМДС | Эмч ажилчдын сэтгэл ханамжийн хувь Хэрэгжүүлсэн ажил | Эмч, ажилчдын ажлын байрны эерэг сэтгэл ханамж -83% | Ажиллах тав тухтай орчинд ажилчдын сэтгэл ханамжийн түвшнийг 90%-с дээш байлгана. Салбар бүрийн ажилчдын амрах өрөөг | Ажилчдын амрах өрөөг тохижуулахаар тендер зарлан гэрээ байгуулж ажил гүйцэтгэх шатанд явж байна. Ажилчдаас авч буй санал асуулгад байгууллагын дотоод орчны тав тухад 94% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тохижуулсан байна. | нь дунджаас дээш үнэлгээг өгсөн байна. | |
| 2.2.1.7 | Ажилтан, ажиллагсдын ёс зүй харьцаа хандлага, хууль эрх зүйн мэдлэг олгох олон талт арга хэмжээ зохион байгуулах. | ҮЭ | Сургалтын тоо, Хамрагдсан ажилчдын тоо, Ёс зүй харьцаа хандлагын зөрчлийн тоо | 2 удаагийн онлайн сургалтад 301 ажилтан хамрагдсан. | Аян-1 /400 хүн/ Сургалт-1/400 хүн/ зохион байгуулсан байна. Ёс зүй харьцаа хандлагын зөрчлийн тоог өмнөх оны үзүүлэлтээс багасгана. | 2022.4.15-17-ны өдрүүдэд байгууллагын эмч, сувилагч, жолооч, инженер техникийн алба, авто бааз, үйлчилгээний нийт 385 ажилтнуудыг хамруулан эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хөдөлмөрийн тухай хууль, эрх зүй сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 2022.11.11-ний өдөр “Сайхан үг сэтгэлийн чимэг, сайхан бүхнийг бусдад түгээе” өдөрлөгийг ХУС-т зохион байгуулсан. 2022.10.01-нд “Эмч, эмнэлгийн мэргэжилтэн зөвлөгөө өгөх ур чадвар эзэмших” 2 цагийн сургалтад 78 эмч хамрагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1.8 | Хувь хүний хөгжлийг сайжруулах сургалт зохион байгуулна | ЭМДС | Сургалтын тоо, Хамрагдсан ажилчдын тоо, | - | 1 удаагийн сургалтад байгууллагын нийт ажилчдыг хамруулсан байна. | 2022.09.16-ны өдөр “ Эмч , эрүүл мэндийн ажилтнуудын хөдөлмөрлөх эрх” , Хүний эрхэд суурилсан хандлага ба төрийн үйлчилгээ “ сургалтад хамрагдсан. 2022.12.16-ны өдөр хувь хүний хөгжлийн академиас сургалт авахаар төлөвлөсөн. | 100% |
| 2.2.2. Чанар, аюулгүй байдлын чиглэлээр | | | | | | | |
| 2.2.2.1 | БЗС, СХС-т яаралтай тусламжийн эмнэл зүйн сургалтын төв нээж тохижуулах | ЭМДС | Эмнэл зүйн төвийн тоо, Нийт сургалт , сургалтад хамрагдсан эмч ажилчдын тоо | Эмнэл зүйн төв-1 Эмч ажилчид, ӨЭМТ-н нийт 910 хүн сургалтад хамрагдсан. | Төвийн нийт эмч, ажилчид НЭМГ-н харьяа байгууллага, ӨЭМТ, төрийн бус байгууллагын 3000 хүн хамрагдсан байна. | БЗС, СХС-т эмнэл зүйн сургалтын төв байгуулах өрөө, тасалгааг гарган ажиллагаагүй болсон тоног төхөөрөмжүүдийг сэлбэн сургалтад ашиглахаар бэлдэж байна. Сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авах тендер нь хэмнэлтийн хуулийн дагуу зарлагдаагүй. Эрүүл мэндийн газартай хамтран “Яаралтай тусламжийн цогц менежмент болон магадлан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | итгэмжлэлийн зөвлөмж” сэдэвт бүсчилсэн ажлын байрны сургалтыг 2022 оны 02 дугаар сарын 22-ноос 03 дугаар сарын 10-ны өдөр хүртэл Сүмбэр суманд Батсүмбэр, Борнуур, Сүмбэр, Жаргалант, Баянчандмань, Аргалант, Баянцогт сумын Эрүүл мэндийн төвүүд, Эрдэнэ суманд Мөнгөнморьт, Баян, Баянжаргалан, Эрдэнэ, Сэргэлэн, Архуст, Баяндэлгэр СЭМТөвүүд, Ар жанчивлан, Өвөржанчивлан, Задгай цагаан, Хайрын билэг сувилал, Баянхангай суманд Заамар, Лүн, Эрдэнэсант, Өндөрширээт, Цээл, Угтаал, Баянхангай СЭМТөвүүд, Дэлгэрхаан суманд Баянцагаан, Баян- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Алтанбулаг СЭМТөвүүдийг тус тус бүсчилсэн нийт 200 эмч эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд онол дадлага хосолсон сургалтыг зохион байгуулсан. | |
| 2.2.2.2 | Хүүхдийн өвчний цогц менежментийн сургалтыг үе шаттай зохион байгуулах | ЭМДС | Сургалтад хамрагдсан эмч ажилчдын тоо | 2021 он ХӨЦМ 46 их эмч сургалтад хамрагдсан. | 2022 онд 50их эмч сургалтад хамрагдана. | 2022.02.15-ны өдөр Хүүхдийн эмч З.Гэрэлмаатай хамтран онлайн сургалт зохион байгуулж 17 эмч хамрагдсан. Шинээр ажилд орсон 57 эмч ХӨЦМ, хүүхдийн эрэмбэлэн ангилалт яаралтай тусламжийн сургалтыг ЧАБА, СА нар орсон. Нярайд үзүүлэх яаралтай тусламж сэдвээр “Амгалан “ АГ-ын эмч багш н.Уранчимэг орж 27 эмч хамрагдсан. | 100% |
| 2.2.2.3 | Эмч, ажилтан, ажиллагсдад тусламж, | ЭМДС | Хамрагдсан эмч, | 125 эмч, эмнэлгийн мэргэжилтэн | 275 эмч, эмнэлгийн | Хэлэлцүүлэг 30 удаа, эмгэг судлалын конференц 13 удаа, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн менежмент, алдаанаас суралцах чиглэлээр сургалт зохион байгуулна. | | мэргэжилтэн, сургалтын тоо | сургалтад хамрагдсан. | мэргэжилтэн хамрагдана. | разбор 11 удаа зохион байгуулж нийт 344 эмч, менежер оролцсон. | |
| 2.2.2.4 | Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулна. | - | Сургалтад хамрагдсан хүний тоо, сургалтын тоо | Хэлэлцүүлэг, тохиолдолд суурилсан сургалтад 80 эмч хамрагдсан. | 2 удаагийн сургалтад 80 эмч, хамрагдана. | Эх барихын тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр 3-р сард Дэлхийн эмч нарын өдрийг угтсан 14 хоногийн аян зохион байгуулсан.<br>1. “Эх хүүхдэд хүрч үйлчилье”<br>2. “Эх барих, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулъя”<br>3. “Тусламж үйлчилгээний чанар сайжруулъя”<br>4. “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулъя”<br>Нийт давхардсан тоогоор 490 хүн хамрагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.2.5 | Эмнэлгийн туслах ажилтан болон инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулна. | ЭМДС | Хамрагдсан мэргэжилтний тоо, үр дүн | 2021 онд 4 сэдвээр 12 удаагийн давтамжтай сургалт зохион байгуулсан | 123 эмнэлгийн туслах ажилтан, 18 инженер техникийн ажилтан хамрагдана. | 2022.05.05-ны өдөр Нийслэлийн түргэн тусламжийн техникийн ажилтны ур чадварыг дээшлүүлье сэдэвт ур чадварын тэмцээнийг жолооч нарын дунд зохион байгуулж 8 инженер техникийн ажилтан, 87 жолооч хамрагдсан. 2022 оны 5-р сарын -27-нд эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор НЭМГ, ЭХЭМҮТ, Нийслэлийн Түргэн Тусламжийн төвийн нийт эмч нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нийт 65 эмч оролцсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.2.6 | Түргэн тусламжийн үйлчилгээний автомашины засвар үйлчилгээний шуурхай байдлыг хангах зорилгоор “Хөдөлгөөнт засварын автомашин”-ыг тоноглох | ЭМДС | Тоноглогдсон автомашины тоо | /-/ | 2022 онд 1 автомашин тоноглосон байна. | Хөдөлгөөнт засварын авто машиныг тоноглоход шаардлагатай тоног төхөөрөмж, материалын судалгааг хийж нийт 19,6 сая төгрөгөөр тоноглохоор төсөв гаргасан. Хил гаалиар бараа материал орж ирэхгүй байгаатай холбоотойгоор түр хугацаанд зогссон байна. | 80% |
| 2.2.2.7 | “Сайн туршлага-2022” арга хэмжээнд оролцох | ЭМДС | Оролцсон салбар нэгжийн тоо, бүтээл, дэлгэрүүлсэн технологийн тоо | 9 сайн туршлагыг нэвтрүүлсэн. | 4 чиглэлээр 9 бүтээлийг танилцуулсан байна | “Сайн туршлага-2022” үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, шилдэг 20 бүтээлд: Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах чиглэлээр ”Цахим мэдээлэл“ бүтээл дэд байранд Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөвчлөх, хүртээмж сайжруулах бүтээлд “Үйлчлүүлэгч дамнуургаар тээвэрлэлтийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөнгөвчлөх, өргөх бүс" бүтээл тусгай байрд шалгарсан байна. | |
| 2.2.3. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр | | | | | | | |
| 2.2.3.1 | Халдварын сэргийлэлт, хяналтын тогтолцоог мөрдөн ажиллах | - | Сургалт, арга хэмжээний тоо | 2021 онд 3 чиглэлийн 25 сургалт давхардсан тоогоор 530 ажилтан хамрагдсан. | 5 чиглэлийн 35 сургалт 430 ажилтан хамрагдана. | Байгууллагын хэмжээнд 6 чиглэлийн 25 сургалт давхардсан тоогоор 463 ажилтан хамрагдсан. Салбар, хэсгийн чанарын багууд 7 чиглэлийн 46 сургалтыг дотооддоо зохион байгуулсан. | 100% |
| 2.2.4. Төсөв, санхүү, санхүүжилтийн чиглэлээр | | | | | | | |
| 2.2.4.1 | Эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлж буй тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүрэн авч өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. | - | Санхүүжилтийн орлогын дүн, хувь | Улсын төсөв, ЭМДСангаас санхүүжсэн. | Нэхэмжлэлийн дагуу санхүүжилтийг 100% бүрдүүлнэ. | 2022 оны 1-р сарын 01-ээс 2022 оны 11-р сарын 30-ны байдлаар тусламж үйлчилгээний дуудлагын бүртгэлийн нэхэмжилсэн дүн 16,995,225,765 төгрөг, гүйцэтгэлийн дүн 16,792,781,965 төгрөг, санхүүжилт олгосон дүн 13,668,461,965 төгрөг, нийт ЭМДСангаас 3,124,320,000 төгрөгийн авлагатай байна. | 98,8% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.4.2 | ТБОНӨХБАҮАТ хуулийн дагуу бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган сонгон шалгаруулалтыг tender.gov.mn сайтаар ил тод олон нийтэд зарлан зохион байгуулна. | | Амжилттай шалгаруулсан тендерийн тоо | 10 тендер Амжилт-100 хувь | 8 тендер Амжилт-100 хувь | 2022 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар 8 тендер, тодотголоор нэмж 5 тендер төлөвлөгдсөн. Үүнээс жилийн эцсийн байдлаар 13 тендер зарлагдан 11 тендер нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу амжилттай тендер шалгаруулалт явагдаж гэрээ байгуулагдсан. 2 тендер нь зарлагдан материал хүлээн авах шатанд явж байна. | 100% |
| 2.2.4.3 | Төсвийн сахилга батыг сайжруулах, ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэн цаг хугацаанд нь шилэн данс, вэбсайт, самбарт мэдээлнэ. | - | Мэдээллийн тоо, хувь | Шилэн дансанд 100% мэдээллийг цаг тухай бүрд нь байрлуулсан. | Шилэн данс, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт цаг тухай бүрд нь мэдээг 100% оруулна. | Цахим хуудасны үндсэн цэсийн танилцуулга хэсэгт үйл ажиллагааны эрхэм зорилго зорилт, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалт зэрэг ил тод байдлыг хангасан 38 мэдээ мэдээлэл, мөн үндсэн цэсэд болон иргэдэд ойлгомжтой байдлаар нүүр хуудсанд тухай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүр шинэчлэн ажилласан. | |
| 2.2.5. Хяналт, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр | | | | | | | |
| 2.2.5.1 | Байгууллагын болон салбар төвүүд, албадын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн | 5 удаагийн удирдамж боловсруулан төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. | Улиралд 1 удаа үнэлгээ хийж биелэлт 90%-с дээш байна. | Байгууллагын хэмжээнд алба, нэгжүүд төлөвлөгөөний дагуу т сар бүр ажлын тайлангаа нэгтгэдэг 1-р улирлын байдлаар төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээний алба дүгнэхэд 91,1% байна. | 100% |
| 2.2.5.2 | Санхүүгийн хөндлөнгийн хяналт, шалгалтад хуваарийн дагуу тогтмол хамрагдаж үнэлэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллах | ЭМДС | Аудитын дүгнэлт | Ямар нэгэн зөрчилгүй ажилласан. | Хуваарийн дагуу шалгалтуудад хамрагдаж үнэлэлт, зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн зөрчилгүй ажиллана. | Санхүүгийн хөндлөнгийн хяналт, шалгалтад өгсөн зөвлөмжийн дагуу үйл ажиллагааг сайжруулж алдаа, зөрчил гаргалгүй ажиллаж байна | 100% |
| **ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 3.1 | Төвийн хэмжээний цаасны хэрэглээг бууруулж байгууллагын хэмжээнд Medsoft программыг бүрэн нэвтрүүлэх. | ЭМДС | Төвийн цаасны хэрэглээ, цахимжилтын хувь | Төвийн хэмжээнд 2021 оны байдлаар 50 орчим цахимд шилжих боломжтой цаасан баримт | Дээрх баримт бичгийг 100% цахимд шилжүүлж цаасны хэрэглээг бууруулна. | Төвийн хэмжээнд 2022 оны 4-р сарын 05-аас Medsoft программыг бүрэн нэвтрүүлж эхэлсэн.<br>Medsoft, ERP, EDOC, Pharmacy зэрэг бүртгэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүртгэгдэж байна. | | программыг нэвтрүүлснээр албан бичиг, эмч нарын дуудлагын хуудас, эмийн сангийн бүртгэл зэрэг цаасан баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна. | |
| 3.2 | Дуудлагын хуудсыг зайнаас цаг хугацаанд нь бүртгэл мэдээлэл хийх таблет, зөөврийн компьютер үйлчилгээнд нэвтрүүлэх. | ЭМДС Ipad-80.4 сая Imac-3.8 сая | Таблет зөөврийн компьютерын тоо, Хэрэглээний хувь | - | Эмч нарын ажлын ачааллыг бууруулж,. Цаг хугацаа алдахгүй ЭМД санд мэдээлэл бүртгэгдэнэ. Ээлж бүрийг таблетаар хангана. | Төвийн хэмжээнд нийт 45 IPad-г нэвтрүүлж, эмч нарыг бодит цаг хугацаанд нь дуудлагын мэдээллийг ЭМД-ын санд илгээх боломжийг бүрдүүлсэн. | 100% |
| 3.3 | Түргэн тусламжийн автомашинуудыг богино долгионы радио станцаар хангах | Нийслэлийн хөрөнгө оруулалт | Хэт богино долгионы радио станц суурилуулсан автомашины тоо | - | Дуудлагын 85-90 автомашинд суурилуулсан байна. | Суурийн станц 5ш<br>Дахин дамжуулах станц 5ш<br>Автомашины станц 90ш<br>Гар станц 20ш суурилуулан хэрэглээнд нэвтрүүлсэн. | 100% |
| 3.4 | Түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах системийг хөгжүүлэх | ЭМДС | Байршил тогтоогч суурилуулсан | 2021 онд 70 автомашинд суурилуулсан. | Байршил зүй GPS хяналтад орно | 2022 онд 17 автомашинд GPS төхөөрөмж худалдан авч нийт 87 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | автомашины тоо | | | автомашиныг GPR төхөөрөмжөөр хангасан. ICT Групп ХХК-тай хамтран ажил хэрэгжүүлж түргэн тусламжийн автомашины байршлыг хянах бүрэн боломжтой болсон. | |
| 3.5 | Иргэдээс ирсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх. | - | Өргөдлийн тоо шийдвэрлэлтийн хугацаа, | 380 талархал, 20 гомдол, Шийдвэрлэлтийн хугацаа 7 хоног | Шийдвэрлэлтийн хугацааг 24 цагаас ажлын 5 өдөрт шийдвэрлэнэ. | 396 талархал, 60 гомдол ирснийг хуулийн хугацаанд иргэний талд шийдвэрлэсэн | 100% |
| 3.6 | Цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл, ярилцлага, зөвлөмж, сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим хуудсаар сурталчлах ажлын зохион байгуулах | ЭМДС | Хэвлэл мэдээллийн тоо | 8 телевиз, 5 сайтад 34 ярилцлага, зөвлөмж Байгууллагын цахим хуудаст 83 төрлийн мэдээлэл, 455725 хандалт | Шаардлагатай тохиолдол бүрд цаг үеийн мэдээллийг үнэн зөв бодитойгоор хүргэх. Байгууллагын цахим хуудаст 100 төрлийн мэдээ мэдээлэл, зөвлөмж тавигдсан байна. | 2022.11.03-ны байдлаар: 2,127,000 зочин хандсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 12.4%-өссөн үзүүлэлттэй байна. Байгууллагын цахим хуудаст 131 төрлийн мэдээ мэдээлэл, зөвлөмж тавигдсан байна. | 100% |
| 3.7 | Байгууллагын иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж зүлэгжүүлж, цэцэрлэгжүүлэх | ЭМДС | Төлөвлөгөө, Хийгдсэн ажлын үр дүн | /-/ | Иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх төлөвлөгөө гарган | 2022.04.02-ны өдөр 6 салбарын нийт 210 ажилчид олон нийтийн талбай, гэрлийн шон, явган хүний зам, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах. | | | | хэрэгжүүлж ажиллана. | автомашины зам зэргийг цэвэрлэн өнгө үзэмжийг нэмэгдүүлэв. Сар бүр салбар төвүүдийн гадна орчны 50м хүртэлх зам талбайд их цэвэрлэгээ хийж орчны хог хаягдлыг цэвэрлэх, устгах, барилгын хана үүд цонх, хаяг, самбар, гадна талбайг угааж цэвэрлэн цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлэн их цэвэрлэгээ, хийж гүйцэтгэсэн. | |

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН ДАРГА С.АРИУНБОЛД

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ОРЛОГЧ ДАРГА П.СУВД

УХЕ0042 9077332